**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/26 Номгон

Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах тухай

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дугаар "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тогтоолын 2.2.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10, 8 дугаар зүйлийн 8.1.4, 10 дугаар зүйлийн 10.1.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 03 тоот "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" тогтоолын нэгдүгээр хавсралтын 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум орон нутагт биеийн тамир, спортын нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах, иргэнийг идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор сумдад биеийн тамирын арга зүйчдийг томилон ажиллуулахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.Биеийн тамирын арга зүйчдийн албан тушаалын жишиг тодорхойлолтыг баталгаажуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйчдийг удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Оюунбаатар)-т үүрэг болгосугай.

3.Сум, орон нутагт ажиллах биеийн тамирын арга зүйчийг мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, ажлын байрны чиг үүрэгт хяналт тавьж, удирдлагаар ханган гүйцэтгэл үр дүнг тооцон ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 14 ны өдрийн А/26 захирамжийн хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- [x] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар

Нэгжийн нэр: Сумын ЗДТГ

Албан тушаалын нэр: Биеийн тамирын арга зүйч

Албан тушаалын ангилал, зэрэглэл: ТҮ-4

Ажлын цаг: Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил: Сум орон нутаг

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

Онцгой нөхцөл: Хамаарахгүй

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Биеийн тамир, спортын салбарын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороо, Биеийн тамир спортын газраас биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр, бодлого, чиглэл, зорилго зорилтын хэрэгжилтийг хангаж, сум орон нутагт биеийн тамир, спортын нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах, иргэнийг идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэхэд мэргэжил арга зүйгээр ханган чиг үүргийн хүрээнд сум, орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийг хангасан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажил арга хэмжээний гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцана.

**Албан тушаалын зорилт:**

1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангах, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулахад санал гаргах, хэрэгжилтийг хангах

2.Сум, орон нутагт биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин бүрдүүлэх, хамтран ажиллах, санал гаргах

3.Сум, орон нутагт хэрэгжүүлж буй биеийн тамир, спортын арга хэмжээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, хамтран ажиллах

4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х, Шийдвэрлэх -Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, төрөөс биеийн тамирын талаар баримтлах бодлого, шийдвэрийг орон нутагт сурталчлан таниулах, санал дүгнэлт гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах | Биеийн тамир, спортын эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилт хангагдсан байна. | Г,Т |
| | 2.Сум, орон нутагт зохион байгуулагдах биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг төлөвлөх хэрэгжилтийг хангах хамтран ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | Г,Т |
| | 3.Сум, орон нутгаас уралдаан тэмцээн, биеийн тамирын арга хэмжээнд оролцох баг тамирчдыг бэлтгэх, дасгалжуулах, мэргэжил арга зүйгээр хангах | Баг тамирчдын амжилт үзүүлэлт нэмэгдсэн байна. | Г,Т |
| | 4.Сум, орон нутагт нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна. | Г,Т |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Сум, орон нутагт биеийн тамир, спортыг хөгжүүлэх заал, гадаа талбай, хэрэглэгдэхүүн, хэрэглэл материалаар хангахад санал дүгнэлт гаргах, хяналт тавих, хамтран ажиллах | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин бүрдсэн байна. | Г,Т |

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх өрөө, танхимыг байгуулах, хамтран ажиллах, мэргэжил арга зүйгээр хангах | Стандартын өрөө танхимыг тохижуулж, иргэдэд үйлчлэх орчинг бүрдүүлсэн байна. | Г,Т |
| | 3.Сум, орон нутгийн биеийн тамирын түүх, хөгжлийг хангасан танхим, олимпийн төвийг байгуулах үйл ажиллагааг өргөжүүлэх | Сум орон нутгийн биеийн тамир, спортын түүх, хөгжил хангагдсан байна. | Г,Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Сум, орон нутагт нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн оролцоог нэмэгдүүлж, мэргэжил арга зүйгээр хангах, хамтран ажиллах | Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоо нэмэгдсэн байна. | Г,Т |
| | 2.Сум, орон нутагт биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах, хамтран ажиллах | Хамтын ажиллагаа сайжирсан байна. | Г,Т |
| | 3.Иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, дасгал хөдөлгөөнөөр идэвхтэй хичээллэх ажил арга хэмжээг тогтмолжуулах, мэргэжил арга зүйгээр хангах | Иргэд эрүүл амьдралын дадал хэвшилтэй болсон байна. | Г,Т |
| | 4.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах хамтран ажиллах | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш оролцоог хангасан байна. | Г,Т |
| | 5.Сум, орон нутагт зохион байгуулагдсан уралдаан, тэмцээн, биеийн тамирын арга хэмжээ, оролцож буй иргэдийн бүртгэл, дасгал хөдөлгөөнөөр идэвхтэй хичээллэж буй иргэдийн судалгаа, мэдээллийн сантай байх | Мэдээллийн сангийн баяжилт хийгдсэн байна | Г,Т |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, гүйцэтгэл үр дүнг тооцуулах, дүгнүүлэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна. | Г |
| | 2.Биеийн тамир, спортын газар холбогдох дээд шатны байгууллага, орон нутгийн удирдлагаас шаардсан чиг үүрэгтэй холбоотой мэдээ тайлан, судалгааг хугацаанд нь чанартай шуурхай гаргах, хүргүүлэх | Бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, чанарт ахиц гарсан байна. | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөн чиг үүргийн дагуу байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримтуудаар хадгаламжийн нэгж бүрдүүлж архивд шилжүүлэх; | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна. | Г |
| | 4.Олон улсын стандарт ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны шаардлагыг хэрэгжүүлэх; | Олон Улсын стандартад нийцүүлэн ажилласан байна. | Г |
| | 5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | Хууль, тогтоомжид заасан чиг үүрэг хэрэгжсэн байна. | Г |

| | | |
|---|---|---|
| [illegible] | | |
| **Боловсрол** | | Бакалавр түүнээс дээш боловсролтой байх |
| **Мэргэжил** | | Багш, биеийн тамирын боловсрол /011410/, спорт /1014/, спортын дасгалжуулагч /101401/, биеийн тамирын арга зүйч /101402/. |
| **Мэргэшил** | | Төрийн албаны мэргэшүүлэх, ур чадвар олгох сургалтад хамрагдаж төгссөн байх. |
| **Туршлага** | | Төрийн албанд мэргэжлээрээ, 2-оос доошгүй жил ажилласан байх |
| | Дүн шинжилгээ | - Судалгааны арга зүй, мэдлэгтэй байх<br>- Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх<br>- Мэдээллийг нэгтгэж, санал зөвлөмж боловсруулах<br>- Ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг тайлагнах<br>- Бусад |
| | Асуудал шийдвэрлэх | - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх<br>- бүтээлч санаачилагч, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх<br>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх<br>- хуулийн эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх<br>- бүтээлч, санаачлагатай ажиллах<br>-бусад |
| | Багаар ажиллах | -өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах<br>-багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх<br>-багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах<br>-мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах |

| | | |
|---|---|---|
| | | -хамт олны зэрэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;<br>- Багийн зохион байгуулагчтай хамтран ажиллах<br>-Бусад |
| | Манлайлах | -ёс зүйн хэм, хэмжээг сахиж, зарчимч, тууштай ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх<br>-шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих<br>-ажил хэргийн хувьд бүтээлч санаачилгатай ажиллах<br>-байгууллагын үйл ажиллагаанд шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх |
| | Бусад | -өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх<br>-ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх<br>-зарчимч тууштай, ажил хэрэгч байх<br>-албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх<br>-компьютерийн хэрэглээний текстэн, хүснэгтэн, үзүүлэн бэлтгэх программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх<br>-төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх<br>-англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх<br>-бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх<br>-хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавих.<br>-монгол бичгээр унших, бичих чадвартай байх |

[illegible]

**<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>**

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

| | |
|---|---|
| **Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:** | **Бусад харилцах субъект**:<br><br>-Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар хэлтэс<br><br>-Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллага, спортын холбоод<br><br>-Иргэн хуулийн этгээд |

[illegible]

| | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
| | |

<table>
<tr>
<td>

**Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:**

**Албан тушаал:**

Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн ахлагч /Биеийн тамир, спортын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн/ /Н.Одончимэг/

2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

</td>
<td>

**Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:**

**Байгууллагын нэр:**

**Биеийн тамир спортын газар**

**Шийдвэрийн огноо:** 2022.0.17

**Дугаар:** А/26

</td>
</tr>
<tr>
<td colspan="2">

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

</td>
</tr>
<tr>
<td colspan="2">

**Байгууллагын нэр:**

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

**Шийдвэрийн огноо:** 2022.01.17

**Дугаар:** А/26

(тамга/тэмдэг)

0320100003 9007822 ГСТ7103

ДАРГА / Б.ОЮУНБААТАР /

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр

</td>
</tr>
</table>